



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/134

Арвайхээр

**Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн П.Мөнхжаргал (ЙЮ80110814)-ын гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 13 дугаар баг Залуучуудын 3 дугаар гудамж 304 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай 1200м<sup>2</sup> газрын зориулалтыг нийтийн орон сууцны, иргэн П.Энхтайван (ВЮ70070954)-ы эзэмшил Төв цэнгэлдэхийн 3 дугаар гудамж 307 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай 809м<sup>2</sup> газрын зориулалтыг нийтийн орон сууцны, иргэн Э.Алтангэрэлийн эзэмшил 8 дугаар баг 27 дугаар гудамж 3 тоотод байрлах нийтийн орон сууцны зориулалттай 884м<sup>2</sup> газрын зориулалтыг худалдаа, үйлчилгээний зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100293